

9 сарын цаг үеийн мэдээ


Боловсролын чиглэлээр:

Ерөнхий боловсрол:

### 1. СУРГАЛТ:


2021-2022 оны хичээлийн жилийн сургалт хүмүүжлийн ажил 278 сурагч 36 багш ажилтантай явагдаж байна. Үүнээс: Бага боловсролд 181, суурь боловсролд 97 сурагч байна. Сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулахад шинээр ажлын байранд дараах багш ажилчдыг авч ажиллаж байна. Үүнд:

1. Монгол хэлний багшаар Х.Сарантуяа багшийг 3 сарын хугацаатай авч ажиллуулж байна.
  2. Насан туршийн нэгжийн багшаар Б.Адъяа 3-н сарын хугацаатай
  3. Физикийн багшаар Ц.Саруул багшийн цагийн багшаар
  4. Математикийн багшаар Ш.Байгальийг ажлын байранд жинхэнээр
  5. Аж ахуйн ажлын Н.Энхцэцэгийг 3-н сарын хугацаатай
  6. Манаачаар Б.Дөлгөөн 2-р сарын хугацаатай түр ажлын байран дээр авч ажиллуулж байна.
- Улс орон даяар цахимаар зохион байгуулагдаж буй "Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэх" сэдэвт сургалтанд багш нар судлагдахуунаараа хамрагдлаа.



- Хичээл сургалтын үйл ажиллагаа 09-р сарын 01-нээс 7 хоног танхимаар явж, 13-17-ны хооронд халдварын тархалт ихсэж зайн хэлбэрт шилжиж багш нар цахимаар сургалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.
- Багш ажилчдын халдвар авсан байдал: Багш сургуулийн хэмжээнд өнөөдрийн байдлаар 7 багш, 2 ажилтан 12 сурагч, ойрын 48 сурагч байна. Эдгэрсэн 1 багш, 2 сурагч
- БСУГ-аас сургалтын менежер сургуулийн захиралуудтай цахим уулзалтыг хийж ажлын чиглэл өгч ажилласан.
- АУБ болон мэргэжлийн багш нар “Боловсролын мэдээллийн систем”-д сурагчдын өдөр бүрийн ирцийн мэдээ болон сургалтын хөтөлбөр төлөвлөгөө шивж оруулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

- БШУЯ, Мобикомоос зохион байгуулж буй "Ухаалаг боловсрол" төсөлд нийт 6 сурагчийн материал явуулсанаас 4а ангийн сурагч Г. Мөнхсоёл шалгарсан гар утасны эзэн болсон.
- Сурлагын хоцрогдолыг арилгах, нөхөх ажлын хүрээнд мэргэжлийн болон АУБ багш нар "Бие даах дасгал ажлын дэвтэр"-ийг хэвлэж сурагчдад тараах ажлыг зохион байгуулсан.




- Дэлхийн түвшний менежер 2 сарын онлайн сургалтанд нийт 8 багш 55000 төгрөгөөр бүртгүүлэн хамрагдаж, цахимаар суралцаж мэргэжил арга зүйгээ дээшлүүлэн ажиллаж байна.
- ЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу "Төрийн албан хаагчийн мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт болгох ажлын хүрээнд ажилтан албан хаагч нараа 2021-09-17-ны дотор / gov.mn , edu.mn/ хаягтай болгон, мэйл хаягийн бүртгэлийн жагсаалтыг хугацаанд нь явуулж ажилласан.

## 2. ТАНДАЛТЫН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Сургуулийн тандалтын багийг сургуулийн захирлын 2021.08.23-ны өдрийн А\06-р тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажлын хэсгийн ахлагчаар нийгмийн ажилтан Д.Ариун-Эрдэнэ, нарийн бичиг дотуур байрны багш О.Ганболд нар БШУС,ЭМС-ийн А\292, А\525 тоот хамтарсан тушаалын түр журмын дагуу тандалт хариу арга хэмжээ авч ажиллах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Үүнд: Танхимаас зайнаас хэлбэрт хичээл сургалтын үйл ажиллагаа шилжсэн үед төлөвлөгөөт хурлыг зохион байгуулж ажиллаж байна.




БШУЯ-наас хэрэгжүүлж буй халдварын эрсдэлээс сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд “Боловсролын салбарын мэдээллийн систем” ашиглан багш, ажилчид, сурагчдын биеийн байдлыг бүртгэж QR кодоор сургууль руу нэвтрэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ



### 3. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ:

Шинэ хичээлийн жилийн Сургуулийн "Хүүхэд хамгааллын бодлого" -ыг түр журмын дагуу шинэчлэн боловсруулж багш, ажилтан, эцэг эхчүүдэд цахимаар танилцуулах ажлыг зохион байгууллаа. Мөн сургуулийн хүүхэд хамгааллын баг нь 9-р сарын анхны хурлыг зохион байгуулж, түр журмын дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.



- АУБ нар нийгмийн ажилтантай хамтран ангийн ажлын “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил, хамгаалал”-ын төлөвлөгөөг гаргаж, ангийн хүүхэд хамгааллын судалгаан дээр ажиллаж байна.

Сургуулийн өмнөх боловсрол:

### Сургалт үйл ажиллагаа

Цар тахалтай холбогдуулан 4,5 настай 77 хүүхдийн эцэг эхтэй холбогдон тэдний санал хүсэлтийн дагуу 62 хүүхдийг бүртгэж, 13 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулан жишиг даалгавар боловсруулж, СӨБ-ыг үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

3 настай Дунд бүлгийн 21 хүүхдүүд нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зайнаас суралцаж байна.

Салбарын яамнаас гаргасан хүүхдийн сургалт болон ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг нийт 62 суралцагчаас 16 нэр төрлийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг бүртгэн авч, хичээл үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тусгаарлагдаж байгаа, ажиглалтанд байгаа, эцэг эхийн саналаар цэцэрлэгт явахгүй байгаа хүүхдийг зайн сургалт руу шилжүүлж, “ЖИШИГ ДААЛГАВАР1,2,3” буюу 120ш тараах материалыг бэлтгэсэн. Мөн багш ажилчдын бэлтгэсэн ном тоглоомын багцыг төрөлжүүлэн жишиг даалгавартай хамтад нь хүргэсэн. Бэлтгэл бүлгийн 30 хүүхдэд ном тоглоомын багцыг хүргэн ажиллаж байна.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ГАЗАР, БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН, БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ-ээс хамтран явуулсан “Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх арилгахад дэмжлэг үзүүлэх сургалт”-д 2 сууж, үүний дагуу танхим болон зайн хэлбэрээр сургалтын хөтөлбөр боловсруулан сургалт үйл ажиллагаагаа явуулж байна.

Түр жумын дагуу өдрийн дэглэм, цэцэрлэгт хүүхдийг хүлээн авах, тарах цагийг нарийн гаргаж, цагийн хуваарийн дагуу үйл ажиллагаа явагдаж байна. Байгууллагын халдвараас сэргийлэх тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байгууллагын туслах багш, үйлчлэгч нарт түр журмын дагуу сургалт хийж зөвөлгөө зөвлөмж өгсөн. 2021.09.16-ны өдөр аймгийн НДХ-ээс зохион байгуулсан ҮОМШӨ-н талаарх сургалтад хамрагдсан.

### **Эрүүл ахуй халдвар хамгаалал**

Өглөө хүүхдийг хүлээн авахдаа болон өдөр унтаж боссоны дараа биеийн халууныг үзэж тэмдэглэл хөтлөж байна.

Хоолны дээжээ өдөр бүр авч 72 цагийн дараа жижүүр багшийн хяналтан дор устгал хийж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна

7 хоногийн ням гараг бүр хүүхдүүдийн биеийн байдал, аймаг, хотоос хүн ирсэн талаар тандалт хийж ажилладаг.

Өдөр бүр хүүхдийн ус уусан тэмдэглэлийг хөтөлдөг.

Өглөө хүлээн авахдаа бүлгийн хүүхэд бүрт QR код уншуулж, цэцэрлэгт нэвтрүүлэх ажил явагдаж байна.

Зуны даалгаварт өгсөн 2ш цэцгийг үрслүүлж, ангидаа ургуулж арчилж байна.

ЭМТөвөөс санаачлан зохион байгуулсан урьдчилан сэргийлэх үзлэг болон В,С вирусны, сахарын шинжилгээнд 13 албан хаагчид хамрагдсан.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хүнсний материал худалдан авах ААН байгууллагаар тендерт Хач Хүлэг ХХК аж ахуйн нэгж шалгарч гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Гэрээт ААН байгууллагаас хүнсний шинжилгээний бичгүүдийг авч ажил хэрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүүхдийн хоол хүнсийг гэрээт ААН байгууллагаас авч байгууллагуу нэвтрүүлэх тухай бүртээ содтой усаар гадна уут сав баглаа боодлыг ариутган халдваргүйжүүлж хүнсний складруу оруулж хэвшээд байна.

Өдөр тутмын хүүхдийн хоол хүнсэнд олгосон хүнсээ өдөрлөгийн дагуу олгож өдөрлөгөө түүн хүнсний тайлангаа цаг тухайд нь гарган ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 08-р сарын 19-ны өдрийн А/292, А/525 тоот тушаалаар батлагдсан түр журмыг уншиж судлан ажил хэрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүүхдийн хоолны цэсээ 5 хоногоор гаргаж батлуулан хүүхдийн хоолыг амин дэмээр баялаг дархлааг дэмжсэн хоол хүнсээр хангаж байна Технологийн картаа цаг тухайд нь хөтөлж хэвшсэн.

7 хоногийн 5 дах өдөр болгон их цэвэрлэгээ хийж ариутгалын бодисоор ариутгал хийдэг.

Тусгаарлах өрөөнд түр журам"-ын 2.1.8,2.1.9 заасан анхны тусламжийн бүрдэл хамгаалах хувцас мөн турбаний мөнгөлөг цаасаар бүрэн хана шохойдож орчны тохижуулсан болон холбогдох бусад хэрэгслийг няраваас хүлээн авч байршуулсан .

Коронвируст халдварын эрсдэлээс, хамгаалах дараах санамж зурагт хуудас хүүхэд, багш, ажилтан, эцэг эх мэдээлэх тэдгээрийг харагдахуйц газар байршуулан ажилласан.

Өглөө бүр цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна.

Дотоод хяналтын багийн гишүүн Г.Эрдэнэцэнгэлийн хамт цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхэд бэлэн эсэх ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж заавар зөвлөгөө өгсөн.

Халдвараас сэргийлэх тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийн нийтэд мэдээллэх мэдээллийг Наран сум хүүхдийн цэцэрлэг гэсэн цахим хаягаар дамжуулан хүргэсэн.

### **Эцэг эхтэй хамтарч ажиллах талаар**

Цэцэрлэгийн захиргаа, багш, эцэг эхийн хамтарсан гурвалсан гэрээг байгуулж, ажлын чиглэл эрх үүрэгтэйгээ танилцсан ба хүүхэд Гэр-Цэцэрлэг-Гэр гэсэн маршрутыг гаргаж мөрдөн ажиллах чиглэл өгсөн.

Эцэг эхээс 62 хүүхдийн болон асран хамгаалагчдын дэлгэрэнгүй бүртгэлийг хийснээр мэдээ мэдээлэлтэй болсон.

8-р сарын 30-нд Эрүүл мэндийн төвтэй хамтран бүлгийн 47 хүүхдийг цагаан хорхойн шинжилгээнд хамруулахад шимэгч хорхой илрээгүй.

Эцэг эхчүүдтэй холбогдон харшил болон ковидын судалгаа авахад эм тарианы харшилтай-1 хүүхэд байсан. Харин ковид-19 өвчнийг өөрөө буюу гэр бүлийн гишүүдийн аль нэг хүрсэн эсэх талаар судалгаа авахад 6 сард 2 хүүхэд, 9-р сард 1 хүүхэд өвчилсөн байсан.

Ангийн группээр дамжуулан БШУС,ЭМС-ын хамтарсан 2021 оы 8-р сарын 19-ний өдрийн А/292, А/525-р тоот “Түр журам батлах тухай” тушаалыг танилцуулж мэдээлэл хүргэсэн. Мөн энэхүү түр журмыг баримтлан сургалт, үйл ажиллагаагаа явуулж байна.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран томуу төст өвчнөөс урьдчилан вакцинд 20ны байдлаар 47 хүүхэд хамрагдаад байна.

1р багийн иргэн У. Сайнхүү, У.Сүхболд нар 40л тараг 5л сүү, мөн тус багийн иргэн Лутбаяр 10л цагаа хандивлаж хүүхдийн дархлааг дэмжин ажиллаж байна.

### **Бүтээлч ажил**

Цэцэрлэгийн гадна 2ш, дотор 6ш камерыг болон дэлгэц хураах төхөөрөмж зэрэг 2.980.000 төгрөгний үнэ бүхий камержуулалтыг бүрэн шинэчилсэн.

Цэцэрлэгийн гадна талын муу усны нүхийг хашаажуулж үнсний савыг бүрэн шинжилж байршуулсан.

Мөн цэцэрлэгийн хашааны үүдэнд хогийг ангилан ялгах үүднээс өнгийн хогийн савуудыг шинэчилэн хийж байршуулсан.

Байгаль орчны чиглэлээр:

Сумын засаг дарга Л.Оч, ИТХ-ын дарга Ө.Гантулга нарын хамтаар Дарьганга сумын нутагт хадлангийн салаа гарахтай холбогдуулан хадлан авах талбайг Дарьганга сумын засаг даргатай хамт очиж хэмжиж хадлангийн салаанд хүлээлгэн өглөө. Мөн сумын засаг дарга, 2-р багийн засаг дарга Ц.Төмөрсүх, газрын даамал Ү.Отгончимэг нартай хамт 2-р багийн нутагт байх Баяндулаан уул орчмын нутагт хадлангийн 3 салаанд 2000 га талбайг хэмжиж өгч гэрээ байгуулж ажилласан





Монгол тарваганы тархац байршил, тоо толгойг гаргах зорилгоор сумын 1-р багийн нутаг болох Хайрханы ширээ, 2-р багийн нутаг болох Баяндулаан уул орчмын нутагт тарваганы мониторинг судалгааг хийж өглөө оройн гарааг харсан. Нийт 15 дош байсан бөгөөд ойролцоогоор 8 тарч, 5 бурхи, 10 гаруй мөндөл байсан.



Сумын хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн Т.Болорчимэгийн хамтаар өрхийн амьжмргааны түвшин доогуур 3 иргэнээр сумын төвийн зам дагуух хог, хаягдал мөн тоглоомын талбай, Ж.Батсуурын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн зэрэг газрын хог хаягдлыг цэвэрлүүлж ажиллаа. Нийт 5 га газраас 101 кг хог хаягдлыг цэвэрлүүлсэн.

Наран сум, Онгон сумын зааг нутаг болох Булан, Зүрх орчмын нутгаар Онгон сумын нутагт байрлах шонхорын отгоос хүмүүс яваад байна гэсэн гомдлын дагуу сумын засаг дарга Л.Оч, ИТХ-ын дарга Ө.Гантулга нарын хамтаар отогт нь очиж уулзаж зөвлөгөө өгч ажилласан.



Аймгийн цаг уур орчны шинжилгээний газар, Сумын цаг уурч Т.Болорсүвдын хамтаар 1-р багийн нутаг Цөнгөрөг, 2-р багийн нутаг Ноён хөндий, 3-р багийн нутаг Тайгын хөндмий зэрэг газруудад бэлчээр талхлалтын явуулын судалгаа хийж гүйцэтгэлээ. Мөн сумын газрын даамал Ү.Отгончимэг, Байгаль хамгаалагч Г.Цолмон, 2-р багийн засаг дарга Ц.Төмөрсүх нарын хамтаар 1, 2-р багийн нутагт 13 цэгт бэлчээрийн фото мониторингийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**Залуучуудын хөдөлмөрт бэлтгэх оролцоо төслийн сургалтанд 5 залууг хамруулж 2 хүний суманд ЭМТ,Соёлын төвд 3 залууг аймагт дадлага хийлгэхээр болоод байна.

“Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны баг ирж суманд 2 өдөр ажилласан малчин өрх-60,төсөвт байгууллага-5,ажилгүй иргэн -70,ажил хөдөлмөр эрхэлж байгаа 18-35 насны -60,хувиараа хөдөлмөр эрхлэгч-30,ААНБ-9 иргэнээс судалгааг авсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр,цар тахлын үед аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр зарлагдсантай холбогдуулж 3 иргэнд мэдээлэл өгөн 3 төслийг хүлээн авч ХХҮГ-т хүргүүлээд байна.



**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа сунгуулах 2 иргэний, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх байгууллагын харъяалалгүй ахмадын асуудлыг хэлэлцсэн.

Хүнсний эрхийн бичгийн 9 сарын олголтыг хийгээд байна.

09 дүгээр сарын 18-нд зорилтот бүлгийн 5 өрхөд ямаа төслийн ямаа олгох ажлыг хийж гүйцэтгэлээ.



**Мал эмнэлэгийн чиглэлээр:**

Орон нутгийн төлөвлөгөөт тарилга болох бруцеллёз, боом, дуут хавдар зэрэг өвчнүүдийн тарилгын гүйцэтгэлийг цахим системд оруулж ажилласан. Мөн галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хүлээн авч гэрээт хоёр ААН-үүдэд тарааж өгсөн.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:**

Малын үүлдэр угсааг сайжруулах, сүрэг сэлбэх зорилгоор Эрдэнэцагааны үзэмчин үүлдэрийн 20 ш хурган хуцыг авчирч ирэх жилд үржилд ашиглахаар бойжуулж байна.

Мөн Ковид-19 цар тахалаас шалтгаалан малчид иргэдэд хөдөө аж ахуйн мэдээ мэдээллийг хүргэх ажил удааширалтай байгаа бөгөөд иргэдэд мэдээлэл олгох үүднээс 3 төрлийн 10 гаруй брошур, тараах материалыг өгөхөөр бэлдсэн.

Мал бүртгэлжүүлэлтийн аяны хүрээнд өөрсдийн байгаа малын эзэмгний нөөцөө тодорхойлон бог малын эзэмгийг захиалахаар Тэргүүн сүрэг компанитай холбогдон нэхэмжлэх хүлээн авч шийдвэрлэхээр ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

**Үндсэн үзүүлэлтүүд:**

- Нийт үзлэг-175
- Урьдчилан сэргийлэх-114
- Артерийн гипертензин эрт илрүүлэг-5
- Чихрийн шижин эрт илрүүлэг-5
- Жирэмсний хяналтанд хамрагдсан-0
- Жинэлсэн хүүхдийн тоо-28
- Эмнэлэгт хэвтсэн-16
- Холын дуудлага-24
- Төвийн дуудлага-74

**Сэргээн засах эмчилгээ:**

Сэргээн засах эмчилгээ том 1 хүнд, хүүхэд 1 хийсэн.

- Нил улаан туяа-1 том хүн
- Зөөлөн бариа -2 том хүн

**Асаргаа сувилгаа**

- Хэсэгчилсэн угаалаа-5
- Цагаан хэрэглэл сольсон -8

Сүхбаатар аймагт 2021,08,24.25- ны өдрүүдэд Их эмч Б.Гантуяа ,С.Зулцэцэг нар “Элэгний хөтөч”,Элэгний оношилгоо,эмчилгээний чадавхижуулах сургалтанд хамрагдсан.



Сумын 4 байгууллагын албан хаагчдаас элэгний В.С вирусын судалгаа авч судалгааг гаргасан.



Сумын иргэдийн В.С вирусын шинжилгээнд хамраагүй болон хамрагдсан иргэдийн судалгааг гаргаж, Шинжилгээнд хамрагдаагүй иргэдтэй холбоо барьж, зөвлөгөө, зөвлөмж өгсөн.

Элэгний В.С вирустэй иргэдэд Их эмч Б.Гантуяа НЭМА С.Зулцэцэг нар "Элгээ хайрлая" сургалтыг зохион байгуулсан.

Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлж

2021,09,04 ковид-19н халдвар дахин бүртгэгдэж нийт тохиолдол 2021,09,20-ны байдлаар 93 тохиолдол бүртгэгдсэн байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа-36

Гэрийн эмчилгээ-28

Эдгэрсэн-30 хүн байна.



Гэрийн эмчилгээний иргэдийн эмийг эмийн сангаас авч багцлан иргэдэд хүргэн өгч өдөр бүр утсаар холбогдон биеийн байдлыг асууж хяналт хийж АОК,МХГ,ЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.

Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын судалгааг гаргаж иргэдтэй холбогдож заавар зөвлөж өгч, ойрын хавьтлыг програмд шивэн оруулж байна.

Ойрын хавьтлын иргэдийг өдөр бүр шинж тэмдгийн болон хяналтын мэдээг авч бидэнд хүргүүлж түүнийг нэгтгэн АОК,МХГ,АЭМГ-т илтгэх хуудсаар хүргүүлж байна.

Өдөр бүр нөхцөл байдлын мэдээг иргэдэд цахимаар хүргэж байна.

Ковид-19 халдвараас сэргийлэх 10 төрлийн зөвлөмж болон анхааруулгыг цахимаар иргэдэд хүргэн ажиллаж байна.